

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА ХАНГАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Нийтлэг журмын зорилго нь Политехник коллежийн /цаашид ПК гэнэ/-ийн үндсэн чиг үүрэг, өдөр тутмын сургалтын үйл явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, анги, танхим, дадлагын газар болон түүний гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх, хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Нийтлэг журам нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н тухай хууль “Хөдөлмөрийн тухай” хууль болон ПК-ийн дотоод журам болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад бичиг баримттай нийцсэн байна.
- 1.3. Нийтлэг журмыг ПК-ийн сургалтын орчинд суралцагсдын сурч боловсрох үйл явц болон багш, ажилтан албан хаагчдын ажиллах ажлын байрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад хяналт тавих үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

Хоёр. ПК – ийн сургалтын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах ажлын зохион байгуулалт

- 2.1. Сургалтын орчинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах, аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг багш, ажилтан, албан хаагчид хариуцан хэрэгжүүлнэ.
- 2.2. Суралцагсдын аюулгүй байдлыг сургалтын зохион байгуулалт, технологийн дагуу үйл ажиллагааг мэргэжлийн багш нарын хяналт доор явуулна.
- 2.3. Суралцагсад дадлагын ажил эхлэх болон дуусах хүртлэх хугацаанд хамтран ажиллаж байгаа ажил олгогчтой хамтын гэрээ хэлэлцээр байгуулах гэрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тусгаж өгөх түүнийг хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулж нийтлэг журмыг баримтлан ажиллана. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи аливаа асуудлыг аль тал хариуцах тухай хамтын гэрээнд заавал тусгаж өгнө.
- 2.4. Шинээр элсэн орж буй суралцагсад болон ажилд шинээр орж байгаа ажилтанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжлийн багш болон мэргэжилтэн заавал өгч гарын үсэг зуруулан, бүртгэлийн хуудас бөглөн ажилд гарах зөвшөөрлийг өгнө.
- 2.5. Нийт ажилтан, албан хаагч, багш нар ажил эхлэхийн өмнө өдөр тутмындавтан зааварчилгааг бичгээр авч гарын үсэг зурснаар ажил эхэлнэ. Дадлагын хичээл эхлэхийн өмнө мэргэжлийн багш суралцагсдад өдөр тутмындавтан зааварчилгаа өгч зааварчилгааны дэвтрийг хөтлөн суралцагсдад танилцуулан гарын үсэг зуруулж тухайн ажлыг эхлүүлнэ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааны дэвтрийг багш өөрийн гараар бичиж хөтлөнө.
Сар бүр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах мэргэжилтэн үзлэг шалгалт хийн ажиллана.
- 2.6. Нийтийг хамарсан аливаа арга хэмжээний өмнө багийн ахлагч нар багийн гишүүдийн ирцийг бүртгэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах мэргэжилтнээс авсан зааварчилгааг багийнхаа нийт гишүүдэд хүргэн ажиллана.
- 2.7. Томилолтоор хөдөө орон нутагт ажиллахаар явахын өмнө хөдөлмөрийн аюулгүй

байдал, эрүүл ахуйн ахлах мэргэжилтэнгээс томилолтын үе дэх аюулгүй ажиллагааны зааварчилгааг авч байна.

- 2.8. Нийт багш ажилтан албан хаагчид жилд нэг удаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд хамрагдаж сургалтын сэдвийн дагуу шалгалт өгч дүгнүүлсэн байна. Шалгалтын үр дүнг сургуулийн удирдлагад танилцуулж дахин шалгалт авах шаардлагатай багш, ажилтан, албан хаагчдын мэдээллийг тухай бүрд нь хүргэж ажиллана.
- 2.9. Албаны менежерүүд ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг мэдээллийг сайжруулах, сургалт зохион байгуулах зэрэг ажлуудад ач холбогдол өгч хамтран ажиллана.
- 2.9.1. Анги танхим, дадлагын газар анхааруулах сануулах тэмдэг тэмдэглэгээг зохих ёсоор байршуулах

Гурав. Хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслийг хэрэглэх тухай

- 3.1. Нийт багш, ажилтан, албан хаагчид ажилд гарахаас өмнө ажлын хувцасыг бүрэн бүтэн, гүйцэт өмсөж хэвшсэн байна.
- 3.2. Ажлын хувцас нь ажилтны биед эвтэйхэн хөдөлгөөн хязгаарлахгүй байх ба мэргэжлээс шалтгаалан материал нь өөр өөр байна.
- 3.3. Авто машины засварчны болон хүнд машин механизмын ангийн суралцагсад дадлагын газарт ажиллахдаа ажлын хувцасыг бүрэн өмсөхөөс гадна биеийн тамирын гутал /пүүз, кэт/ -тэй ажиллахыг хатуу хориглоно.
- 3.4. Барилгын ангийн болон барилгын сантехникийн ангийн суралцагсад толгой хамгаалах каскыг байнга өмсөж хэвшсэн байх ба ажил удирдаж байгаа багшаас мөн сургалтын тоног төхөөрөмж, дадлагын хариуцсан ажилтанаас хүлээн авч өмсөж хэрэглээд хичээл дуусахад буцаан өгч байна. Мөн өндөрт болон газар доор ажиллах үед тухайн ажлын онцлогт тохирсон аюулгүй ажиллагааны зааварчилгааг заавал бичгээр авч гарын үсэг зурсны дараа ажил гүйцэтгэнэ. Бусад ангийн авто машин засварчин, хүнд машин механизмын засварчны ангийн суралцагсад, оператор, хүнд машин механизмын мөн цахилгаан гагнуурчин, барилгын модон хийцийн мужааны ангийн суралцагсад саравчтай малгайг өмсөж дадлагын газарт ажиллана. Оёмол бүтээгдэхүүний оёдлын ангийн суралцагсад болон тогооч, хоол үйлдвэрлэлийн технологич, талх, нарийн боов үйлдвэрлэлийн технологич мөн гоо сайханч зэрэг ангийн суралцагсад тус бүрийн мэргэжлийн онцлогт тохирсон толгой хамгаалах хэрэгсэл /малгай/-г өмсөж ажиллана.
- 3.5. Гар хамгаалах хэрэгслийг барилгын бүх төрлийн мэргэжлийн ангийн суралцагсад, цахилгаан гагнуурчны ангийн суралцагсад, барилгын модон хийцийн мужааны ангийн суралцагсад, авто машин засварчин болон хүнд машин механизмын ангийн суралцагсад дадлагын ажил хийх бүрт өмсөж хэвшсэн байна.
- 3.6. Чих хамгаалах хэрэгслийг цахилгаан гагнуурчны ангийн суралцагсад мөн барилгын модон хийцийн мужааны ангийн суралцагсад дуу чимээ ихтэй дадлагын газарт заавал хэрэглэнэ.
- 3.7. Амны хаалтыг тоос шороо, тоосонцор ихтэй нөхцөлд хэрэглэнэ. /Оёмол бүтээгдэхүүний оёдолчны ангийн суралцагсад оёдлын эсгүүр хийх ажлын үед, барилгын засал чимэглэл, барилгын модон хийцийн мужаан, барилгын сантехник, авто машины засварчин, хүнд машин механизмын ангийн суралцагсад дадлагын ажил хийх үед/
- 3.8. Нүд хамгаалах хэрэгсэл болох нүдний шилийг мөн хэрэглэж хэвшсэн байна.

/Оёмол бүтээгдэхүүний оёдолчны ангийн суралцагсад товч хадах машин дээр ажиллах үед, цахилгаан гагнуурчны ангийн суралцагсад дадлагын ажил хийх үед, барилгын модон хийцийн мужааны ангийн суралцагсад, барилгын сантехникийн ангийн суралцагсад дадлагын ажил хийхдээ өмсөнө/

- 3.9. Ажлын хувцас болон тус бүрийн хамгаалах хэрэгслийг сургуулиас хангажбайгаа тохиолдолд дадлагын ажил дууссаны дараа багшид болон сургалтын тоног төхөөрөмж, дадлагын хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч заншина. Нийт багш, ажилтан, албан хаагчид болон суралцагсад нь хөдөлмөрхамгааллын хувцас болон хамгаалах хэрэгслийг гадуур өмсөж явахыгхориглоно.
- 3.9.1. Нийт багш, ажилтан, албан хаагчид ажлын хувцас хамгаалах хэрэгслийг эдэлгээний хугацаанд цэвэр гамтай хэрэглэнэ.

Дөрөв. Техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа

- 4.1. Техник тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг ханган ажиллах, Сургалтын тоног төхөөрөмж, дадлагын газар хариуцсан ажилтан бүр өөрийн хариуцсан дадлагын газрын техник тоног төхөөрөмж тус бүр дээр техник ашиглалтын паспортыг заавал хөтлөнө.
 - 4.1.1. Дадлагын газарт ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийсэн хөтлөлтийг техник ашиглалтын паспортын засвар үйлчилгээ хийгдсэн тухай тэмдэглэлд сургалтын тоног төхөөрөмж дадлагын газар хариуцсан ажилтан, мэргэжлийн багш нар тэмдэглэж ажиллана.
 - 4.1.2. Техник, тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалтын бүрэн бүтэн байдалд шалгалт үзлэгийг хийж, ажил эхлэхээс өмнө заавал шалгаж байна.
- 4.2. Нийт багш, ажилтан албан хаагчид аливаа тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийхдээ технологийн дагуу, заавартай танилцаж хийж гүйцэтгэнэ.
- 4.3. Багшийн зөвшөөрөлгүй аливаа техник хэрэгслийг асаахыг хатуу хориглоно.
- 4.4. Нийт багш, ажилтан, албан хаагчид болон суралцагсад нь техник, тоног төхөөрөмж хэвийн бус дуугарах, гацах, цахилгааны масс үүсэх үед шууд унтрааж аюулгүй байдлыг ханган ажиллана.
 - 4.4.1. Эвдрэл үүссэн техник, тоног төхөөрөмжийг мэргэжлийн засварчнаар оношлуулж засвар үйлчилгээг хийлгэнэ.
 - 4.4.2. Барилгын ажлын үед угсармал шат вандан дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилга авч, технологийн дагуу угсарч, угсарсан шат вандангийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

Тав. Ажлын байрны аюулгүй ажиллагаа

- 5.1. Нийт багш, ажилтан, албан хаагчид аливаа ажил, үүргийг эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах мэргэжилтнээс бичгээр болон амаар авч гарын үсэг зурж ажиллана.
- 5.2. Нийт багш, ажилтан, албан хаагчид тухайн ажил, үүргийг биелүүлэхдээ хувийн бэлтгэлийг сайтар ханган ажлын хувцас хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэт хэрэглэж ажиллана.
- 5.3. Нийт багш, ажилтан, албан хаагчид болон суралцагсад тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, материалыг эмх цэгцтэй байрлуулан ажлын байрны аюулгүй байдлыг ханган ажиллана.
- 5.4. Нийтлэг журмыг сургуулийн нийт ажилтан, албан хаагчид, багш, суралцагседад уншиж танилцуулан мөрдүүлэн ажиллана.
 - 5.4.1. Нийтлэг журмыг ангийн буланд байрлуулсан байна.

- 5.4.2. Нийт анги удирдсан багш нар суралцагсад нэг бүрт танилцуулан уншуулсан байна.
- 5.5. Нийт багш, ажилтан, албан хаагчид анги танхим, дадлагын газрын аюулгүй байдлын үүднээс цахилгаан хэрэгслийг хэрэглээгүй байгаа үед заавал унтрааж байна.
- 5.5.1. Анги танхим, дадлагын газар хариуцсан багш болон тухайн дадлагын газрыг хариуцсан сургалтын тоног төхөөрөмж, дадлагын газар хариуцсан ажилтан нар нь анги танхим, дадлагын газрын ариун цэвэр, аюулгүй байдлыг ханган багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эмх цэгцтэй байрлуулсан байна.
- 5.6. Нийт багш, ажилтан, албан хаагчид тухайн анги танхим, дадлагын газрын усны цорго болон халаалтын системийн аюулгүй ажиллагааг ханган ажиллана.
- 5.6.1. Аливаа эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд мэргэжлийн ажилтанд мэдэгдэж тухай бүрд нь засвар үйлчилгээг хийлгэн ажиллана.
- 5.7. Нийт багш, ажилтан, албан хаагчид цахилгааны аюулгүй байдлыг ханган ажиллаж, уртасгагч залгуурын даацыг хэтрүүлэхгүй байх хамгаалах бүрхүүл гэмтсэн эсэхийг болон халалт үүссэн эсэхийг шалган ажиллаж байна.
- 5.7.1. Цахилгаан хэрэгсэл болон цахилгаан үүсгүүрт эвдрэл гарсан тохиолдолд цахилгаанчинд мэдэгдэж мэргэжлийн хүнээр засвар үйлчилгээг хийлгэн ажиллагааг хэвийн болсон эсэхийг шалгуулсны дараа ажиллуулна.
- 5.8. Нийт багш ажилтан, албан хаагчид болон суралцагсад хог хаягдлыг зориулалтын хогийн саванд хийж байх
- 5.8.1. Үйлчлэгч нар цэвэрлэгээний багаж хэрэгслийг эмх цэгцтэй байрлуулж байх
- 5.8.2. Үйлчлэгч нар нойтон цэвэрлэгээ хийж байх үедээ аюулгүй байдлыг сахин ажиллах, бусдад нойтон шал байгааг сануулж байх.
- 5.8.3. Үйлчлэгч нар болон химийн лабораторийн багш, ажилтан, албан хаагчид аливаа химийн бодис / угаалгын нунтаг, зориулалтын бодисууд/-ыг хэрэглэхдээ анхаарал болгоомжтой байх ба хамгаалах хэрэгсэл /бээлий, амны хаалт, халад, ажлын хувцас/ хэрэглэж байх
- 5.8.4. Нийт багш, ажилтан, албан хаагч, суралцагсад цаасан хог хаягдлыг ангилан хаяж байна.
- 5.9. Нийт багш, ажилтан, албан хаагчид, суралцагсад сургуулийн орчинд / дотор болон гадна/ архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хатуу хориглоно.

Зургаа. Жижүүрийн ажлын байран дахь аюулгүй ажиллагаа

- 6.1. Ажлын байрын аюулгүй байдлыг ханган ажиллах, ажлын хувцсыг өмсөжхэвших
- 6.2. Сургуулийн анги, танхим, дадлагын газарт үзлэг шалгалт хийж байх
- 6.3. Жижүүрүүд ээлж хүлээлцэх үед рапортоор ажлаа хүлээлцэх
- 6.3.1. Ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцан гарын үсэг зурж, ажил эхлүүлэх
- 6.4. Жижүүрүүд тус бүрийн ажлын байрыг эмх цэгцтэй байлгах
- 6.4.1. Тусламж дуудах утасны жагсаалтыг нүдэнд ил газар байрлуулсан байх
- 6.4.2. Түлхүүр ашиглалтын журмыг баримтлан ажиллах
- 6.4.3. Жижүүрүүд ажлын байрын болон сургуулийн аюулгүй байдал алдагдсан тохиолдолд албаны менежерт болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах мэргэжилтэнд мэдэгдэж байх
- 6.5. Жижүүрүүд гадны хүн нэвтрүүлэхдээ биеийн байцаалт болон хэнтэй уулзах, ямар ажлаар явж байгааг тодруулан асууж байх
- 6.5.1. Тухайн ажилтны өрөө, анги танхимыг зааж өгөх эсвэл тухайн ажилтныг утсаар

дуудах

- 6.5.2. Сургууль руу согтуу болон согтууруулах, мансууруулах зүйл хэрэглэсэн хүнийг нэвтрүүлэхгүй байх
- 6.6. Нийт суралцагсдын хичээл тарсны дараа сургуулийн байранд сэлгүүцүүлэхгүй байх, сэлгүүцэж байгаа үйлдлийг анги даасан багшид, сургалтын тоног төхөөрөмж, дадлагын газар хариуцсан ажилтанд мэдэгдэж байх
- 6.6.1. Нийт суралцагсдад шаардлага тавьж, анхааруулж байх
- 6.6.2. Нийт суралцагсдыг үймж шуугиулахгүй байх, ноцолдох зэрэг үйлдлийг зогсоох, анхааруулах, анги даасан багшид мэдэгдэх арга хэмжээг авна.

Долоо. Дотуур байран дахь аюулгүй ажиллагаа

- 7.1. Дотуур байрын багш, ажилтан нар дотуур байрын аюулгүй байдлыг ханган ажиллах, дотуур байранд амьдарч байгаа суралцагсдын өрөө тасалгааг цэвэр, эмх цэгцтэй байлгах үзлэг хийж анхааруулж байх
 - 7.1.1. Дотуур байранд амьдарч байгаа суралцагсад цонхоор цээжин биеийгил гаргах цонхны гадна талын тавцан дээр гутал бусад эд юмс тавихыг хориглоно.
 - 7.1.2. Дотуур байранд амьдарч байгаа суралцагсад дотуур байрын тагтан дээр гарах үедээ аюулгүй байдлаа хангаж хэт их доош тонгойж харахгүй байх, анхаарал болгоомжтой байх дотуур байрны багш нар болон, нийт ажилтан, албан хаагчид, багш нар анхааруулах, таслан зогсоох арга хэмжээ аван ажиллах
 - 7.1.3. Дотуур байранд амьдарч байгаа суралцагсад өрөө тасалгаанд байгаа эд хогшлийг эзний ёсоор ариг гамтай хэрэглэх
 - 7.1.4. Дотуур байранд амьдарч байгаа суралцагсад дотуур байранд архи уух, тамхи татахыг хатуу хориглоно.
 - 7.1.5. Дотуур байранд амьдарч байгаа суралцагсад оройн цагаар гадагш гарахдаа дотуур байрны багшид урьдчилан мэдэгдэх, хаашаа ямар зорилгоор явж байгаагаа хэлж байх, шаардлагатай бол хамт явах хүний утасны дугаарыг үлдээж байх /дотуур байрны багш нар уулзах хүнтэй нь холбоо барих/
- 7.2. Дотуур байранд амьдарч байгаа суралцагсад өрөө тасгийн түлхүүрийг жижүүрт болон дотуур байрын багшид үлдээж байх
- 7.3. Дотуур байранд амьдарч байгаа суралцагсад цахилгааны аюулгүй байдлыг сайтар шалгах, заавал салгаж байх
- 7.4. Дотуур байранд амьдарч байгаа суралцагсад гутлаа сайтар арчиж тасагт байх үедээ гэрийн шаахай өмсөж байх

Найм. Гал тогооны аюулгүй ажиллагаа

- 8.1. Гал тогооны аюулгүй байдлыг ханган ажиллах, тогооч, туслах тогооч болон дадлага хийж буй суралцагсад ажлын хувцас өмсөж хэвших, ажлын хувцсыг цэвэрлэж байх, ажлын хувцас өмсөөгүй тохиолдолд гал тогоонд ажиллахыг хориглоно.
 - 8.1.1. Гал тогооны хэсэгт ажиллахдаа багш, тогооч нар цагаан өнгийн гутал өмсөх, халад, хормогч зүүх, малгай өмсөж ажиллах
 - 8.1.2. Гал тогоонд ажиллаж байгаа багш, ажилтан нар гарын ариун цэврийг сайтар сахих
 - 8.1.3. Гадуур хувцастай ажилтан, албан хаагчдыг нэвтрүүлэхгүй байх, шаардлагатай хэрэгсэл, хурц иртэй хутгатай харьцах үеийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах
- 8.2. Багш, гал тогооны тогооч, туслах тогооч нар болон суралцагсад гал тогооны хэрэгсэл, хурц иртэй хутгатай харьцах үеийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах
 - 8.2.2. Багаж хэрэгсэл /хутга, ногоо арилгагч, хоолны халбага, сэрээ бусад/-ийн ариун цэврийг сахин сайтар угааж байх, тогтсон нэг газар байрлуулах
- 8.3. Тогооч, тогоочийн туслах ажилтан, багш нар хүнсний бүтээгдэхүүний чанар,

аюулгүй байдалд анхаарах

- 8.3.1. Ханган нийлүүлэгчээс хүнсний бүтээгдэхүүн хүлээн авахдаа сайтар үзэж шалгаж авах, шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг тухай бүрд буцаах
- 8.3.2. Хүнсний бүтээгдэхүүний хадгалалтанд анхаарах, зөв хадгалах
- 8.4. Тогооч, тогоочийн туслах ажилтан нь аяга тавгийг сайтар ариутган угааж, цэвэрлэж байх
- 8.5. Тогооч, тогоочийн туслах, сургалтын тоног төхөөрөмж, дадлагын газар хариуцсан ажилтан нар цахилгаан хэрэгслийг хэрэглээгүй тохиолдолд салгаж хэвших
- 8.5.1. Ажил дууссаны дараа өрөө, тасалгаа /хөргүүрийн өрөө, хувцас солих өрөөгэм мэт/-г дахин нягтлан шалгаж байх / цоргоны хаалтыг гүйцэт хаасан эсэх, цахилгаан хэрэгслүүдийг унтраасан эсэх, уртасгагч залгуурын хамгаалалтын бүрээсийг шалгах, халсан эсэхийг шалгах гэм мэт/
- 8.6. Гал тогооны цэвэрлэгээг цаг тухай бүрд сайтар хийж байх
- 8.6.1. Шалан дээр асгарсан шингэн зүйл / ус, ургамлын тос, бусад тос/-ийг тухай бүрд арчиж цэвэрлэж байх / хальтирч унахаас сэргийлэх/
- 8.7. Багш болон сургалтын тоног төхөөрөмж, дадлагын газар хариуцсан ажилтан нь дадлагын ажил хийх гэж буй суралцагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулсан байх

Ес. Бусад

- 9.1. Нийт багш, ажилтан, албан хаагчид, суралцагсад өөрийн болон бусдын биед учирч болох аюулыг харсан бол бусдадаа сануулах, анхааруулах, хариуцсан ажилтанд мэдэгдэх
- 9.2. Нийт багш, ажилтан, албан хаагчид “Гамгаас хамгаалах төлөвлөгөө”-ний өөрт оногдсон үүргийг мэддэг байх
- 9.3. Нийт багш, ажилтан, албан хаагчид, суралцагсад аливаа аюулын үед айж, сандралгүй тайван байж яаралтай арга хэмжээг авдаг байх
- 9.4. Нийт багш, ажилтан, албан хаагчид, суралцагсад нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах мэргэжилтний тавьсан шаардлагыг биелүүлдэг байх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах мэргэжилтэн ажлын байрын аливаа зөрчлийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгч хяналт тавин ажиллах

Арав. ХАБЭА-н журам зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ

- 10.1. Нийт багш, ажилтан, албан хаагчид, суралцагсад нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын болон тухайн цаг үеийн ажилд тохирсон зааварчилгаа болон ПК - ийн нийтлэг журмыг зөрчсөн тохиолдолд сургуулийн дотоод журмын дагуу хариуцлага тооцно.
- 10.2. Нийтлэг журмын 5.9 дүгээр журмыг зөрчсөн тохиолдолд сургуулийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.